


ГОЛОМТ БАНК ХК

2026 оны хагас жилийн үйл ажиллагааны тайлан
Аудитлагдаагүй санхүүгийн үр дүн

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ

Эдийн засгийн өсөлт

жилийн өсөлт (2015 он суурь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2026 оны 5-р сарын байдлаар Монгол улсын эдийн засгийн өсөлт 7.3%-д хүрсэн бөгөөд өсөлтөд голлон уул уурхайн салбарын өсөлт нөлөөлжээ.


Эдийн засгийн салбаруудын оролцоо 2026.05:

- ХАА 1.5%
- Уул уурхай 3.7%
- Үйлдвэрлэл, барилга 0.3%
- Тээвэр, үйлчилгээ 1.9%
- Бүтээгдэхүүний цэвэр татвар -0.1%

2026Q1: гол нөлөө үзүүлж буй салбарууд

Уул уурхай	+5.0%	Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нүүрсний экспорт сайжирч, Оюу толгойн далд уурхайн үйлдвэрлэлээр зэсийн олборлолт нэмэгдсэн нь уул уурхайн салбарын өсөлтийг тайлбарлаж байна.
Тээвэр	+1.1%	Уул уурхайн салбарын өсөлттэй уялдан тээврийн салбарын өсөлт сэргэж, өмнөх оны мөн үеэс 23%-иар өслөө.
Хөдөө аж ахуй	+0.4%	Хөдөө аж ахуйн салбар 2025 онд 33 хувиар өссөнөөс хойш 2026 онд үйлдвэрлэл тогтворжиж, эдийн засгийн өсөлтийг дэмжих нөлөө саарлаа.
Худалдаа & боловсруулах	-0.5%	Худалдааны салбар өмнөх оны мөн үеэс 0.8%-иар, үйлдвэрлэлийн салбар 6.6%-иар тус тус буурч, эдийн засгийн өсөлтөд сөрөг нөлөө үзүүлсэн нь дотоод эрэлт суларч эхэлснийг илтгэж байна.

Өрхийн Бодит Орлого Зарлага Жилийн Өсөлт



Эх сурвалж: YCX


Нэрлэсэн Цалингийн Өсөлт Болон ХАМ (PMI) Индекс



Эх сурвалж: YCX

ГАДААД ХУДАЛДАА

Гадаад худалдааны өсөлт
жилийн өсөлт




Эх сурвалж: Монголбанк

10,393 САЯ USD
НИЙТ ЭКСПОРТ


6,116 САЯ USD
НИЙТ ИМПОРТ

4,277 САЯ USD
ТЭНЦЭЛ

ЭКСПОРТ




ИМПОРТ



МӨНГӨНИЙ БОДЛОГО

Инфляц ба Бодлогын хүү



■ Мах




■ Шатахуун



■ Импортын бараа



■ Дотоодын бараа



Хүнс болон шатахууны үнийн өсөлтөөс шалтгаалж инфляц эргэн нэмэгдээд байна.

- Инфляцын түвшин 6-р сард улсын хэмжээнд 12.0 хувь гарсны 6.8 нэгж хувь (56.4%) нь хүнсний үнийн өсөлтөөс шалтгаалж байна. Харин импортын барааны үнийн өсөлт 2.8 нэгж хувийг (22.9%) тайлбарлаж байна.
- Хүнсний бүлгийн инфляцын дийлэнхийг махны үнийн өсөлт (46.7%) тайлбарлаж байна. үүнд:
 - Үхрийн махны үнэ 57.1%,
 - Хонь, ямааны махны үнэ 60.0% тус тус өссөн
- Нийт инфляцын 0.9 нэгж хувь нь шатахууны үнээс шалтгаалж байна.
- Цаашид мөнгөний бодлого хатуу төлөвт хадгалагдаж, нийлүүлэлтийн шалтгаантай үнийн өсөлтийг хязгаарлахаар ЗГ-аас авч буй арга хэмжээнүүдийн нөлөөллөөр инфляц оны эцэст эргэн буурах хүлээлттэй.

Мөнгөний бодлогын шийдвэрүүд 2026Н1:



MONGOLBANK
CENTRAL BANK OF MONGOLIA

2026.01.16 (Макро зохистой бодлого):

- Хэрэглээний зээлийн ӨОХ-г 45 хувь болгох
- Банкнудын ЗБН-ийн хувь хэмжээг 1 нэгж хувиар нэмэгдүүлэх

2026.03.20:

- Бодлогын хүүг 12 хувьд хэвээр хадгалах


2026.04.28 (Макро зохистой бодлого):

- Банкны гадаад зах зээлээс 2026 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс хойш шинээр татсан 360 хоногоос 3 жил хүртэлх хугацаатай гадаад валютын бонд болон зээлийн эх үүсвэрийн 25 хувьтай тэнцэх дүнг заавал байлгах нөөц тооцох эх үүсвэрт хамруулах.


2026.06.24:

- Бодлогын хүүг 12 хувьд хэвээр хадгалах (инфляцын төлөвөөс хамаарч цаашид өсгөж болзошгүй)

МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ, БАНКНЫ САЛБАР



Эх сурвалж: Монголбанк





**II УЛИРЛЫН ОНЦЛОХ
ҮЙЛ ЯВДАЛ**

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД



GOLOMT BANK
Something for a brighter future

GOLOMT BANK JSC ISSUES
US\$500
MILLION
SENIOR NOTES AT
7.95%

ORDER BOOK REACHES
US\$2.1 BILLION.

Голомт банк олон улсын хөрөнгийн зах зээлд дахин бонд гаргалаа

Голомт банк олон улсын хөрөнгийн зах зээл дээр нээлттэй арилжаалагдах 3 жилийн хугацаатай, 7.95 хувийн купонтой ам.долларын бондыг Нью-Йоркийн хуулиар зохицуулагддаг 144A болон Reg S форматаар амжилттай гаргаж, Сингапурын хөрөнгийн биржид бүртгэснээр нийт 500 сая ам.долларын санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүллээ.



GOLOMT BANK

ISSUER RATING/ LONG TERM DEPO RATING

▲ **B1 Stable**

MOODY'S

Голомт банкны үнэт цаас гаргагчийн зэрэглэл нэмэгдлээ

Moody's Ratings (Moody's) агентлаг Голомт банкны гадаад болон дотоод валютын урт хугацаат хадгаламжийн зэрэглэл, үнэт цаас гаргагчийн зэрэглэл болон гадаад валютын өр төлбөрийн зэрэглэлийг B2-оос B1 болгон нэмэгдүүллээ.

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД



Азийн Хөгжлийн Банкнаас 64 сая долларын санхүүжилт татлаа

Голомт банк Азийн хөгжлийн банк болон Ази тивийн хувийн хэвшлийн уур амьсгал ба байгальд ээлтэй хөрөнгө оруулалтыг дэмжих Канадын сантай хамтран жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, түүнчлэн эрчим хүчний хэмнэлт, хаягдал усны менежмент, тогтвортой хөдөө аж ахуйг хөгжүүлэх төслүүдийг санхүүжүүлэх чиглэлд хамтын ажиллагаагаа эхлүүлж, санхүүжилтийн гэрээнд гарын үсэг зурлаа.



Энэтхэг улсын ЭКСИМ банктай хамтын ажиллагааны гэрээг байгууллаа

Азийн Хөгжлийн Банкны Удирдах зөвлөлийн 59 дэх удаагийн хурал Бүгд Найрамдах Узбекистан улсын Самарканд хотноо зохион байгуулагдаж, дэлхийн 69 улсын 3,000 гаруй төлөөлөгчид оролцлоо. Голомт банкны удирдлагууд өндөр түвшний хэлэлцүүлгүүдэд оролцож, Энэтхэг улсын Экспорт, импортын банктай Худалдааны санхүүжилтийн хамтын ажиллагааны гэрээг байгууллаа.

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД



Цэнхэр санаачилгыг дэмжигч, Усны элч банк

Голомт банк усны нөөцийн тогтвортой менежмент, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох шийдлүүдийг дэмжих зорилгын хүрээнд Global Climate Partnership Fund (GCPF)-ын санхүүжилтээр GOPA Tech зөвлөх үйлчилгээний байгууллагуудтай хамтран үйлдвэрлэлийн салбарын харилцагчдад зориулсан урьдчилан цэвэрлэх байгууламжийн техник туслалцааны ажлыг амжилттай хэрэгжүүллээ



Голомт банк АНЭУ-ын Mashreq банканд Дирхам валютын данс нээлээ


Голомт банк дирхам (AED) валютын данс нээж, харилцагчдынхаа хэрэгцээ шаардлагад нийцүүлэн гадаад төлбөр тооцооны шийдлийг өргөжүүллээ. Дирхам валютын сонголт нэмэгдсэнээр Голомт банкны харилцагчид АНЭУ руу тус улсын үндэсний мөнгөн тэмдэгт дирхамаар түргэн шуурхай, шимтгэл багатайгаар шууд төлбөр тооцоо гүйцэтгэх боломжтой боллоо.

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД



Голомт банкны 2026 оны хувьцаа эзэмшигчдийн хурал боллоо

Голомт банкны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 4-р сарын 06-нд танхимын болон зайнаас хосолсон хэлбэрээр зохион байгуулагдаж, хуралд саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчид 88.65 хувийн ирцтэйгээр оролцлоо.



Голомт банкны 2025 оны үйл ажиллагааны ашгаасаа ногдол ашиг хуваариллаа

Голомт банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 2-р сарын 13-ний өдрийн ээлжит бус хурлаар 2025 оны цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчдэд нэгж хувьцаанд 80 төгрөг, нийт 64.7 тэрбум төгрөгийг мөнгөн хэлбэрээр хуваарилахаар шийдвэрлэж, 4-р сард ногдол ашиг хуваариллаа:

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД



ТОП-100 аж ахуйн нэгжээр Голомт банк өргөмжлөгдөж, 5 дугаарт эрэмбэлэгдлээ

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулж буй 2025 оны ТОП-100 аж ахуйн нэгжээр Голомт банк өргөмжлөгдөж, 5 дугаарт эрэмбэлэгдлээ. Голомт банк 2025 онд борлуулалтын орлогоор 5-рт, татвар төлөлтөөр 7-рт, даатгуулагчийн тоогоор 5-рт, нийт ашгийн хэмжээгээр 4-рт, хөрөнгийн хэмжээгээр 5-р байрт эрэмбэлэгдсэн байна.



Голомт банк "Татвар төлөлтөөрөө тэргүүлэгч" байгууллагаар шалгарлаа.

Монгол Улсын Засгийн газар, Монголын татварын албанаас 2025 оны шилдэг татвар төлөгч аж ахуйн нэгж, байгууллагуудыг өргөмжиллөө. 2025 онд Голомт банк нийт 257.4 тэрбум төгрөгийн албан татвар, хураамжийг улсын төсөвт төвлөрүүлснээр шилдэг татвар төлөгчдийн жагсаалтад 9 дүгээрт эрэмбэлэгдлээ.

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

Голомт банк болон Төрийн банк хамтын ажиллагаагаа өргөжүүлэн “И-Билл үйлчилгээ”-г хөгжүүлж, SocialPay аппликэйшнд нэвтрүүлээ

Уг үйлчилгээг ашигласнаар иргэд эрчим хүч, орон сууцны ус, дулааны төлбөр, СӨХ, интернэт, кабелийн телевизийн үйлчилгээ зэрэг тогтмол төлөх хэрэглээний төлбөрүүдээ гар утсаараа төлөх боломжтой болж байна


EBILL ҮЙЛЧИЛГЭЭ

Н Э В Т Э Р Л Э Э

Хэрэглээний бүх төлбөрөө нэг дороос хялбар төлөх шийдэл

SocialPay аппликэйшний хэрэглээний төлбөр цэс шинэчлэгдлээ.

 SocialPay x 



ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД



Apple Pay төлбөрийн хэрэгсэлд өмнө нь зөвхөн Mastercard болон T брэндийн картыг холбох боломжтой байсан бол одооноос эхлэн Visa брэндийн картыг холбох шийдлийг шинээр нэвтрүүллээ

Ингэснээр Голомт банкны харилцагчдын хувьд Apple Pay-д холбох боломжтой картын сонголт илүү өргөн болж байна.

ОНЦЛОХ БҮТЭЭГДЭХҮҮН

“Ногоон өрх” хэрэглээний зээлийг нэвтрүүллээ.

Голомт банк болон Азийн хөгжлийн банк эрчим хүчний хэмнэлт, хаягдал усны менежмент, тогтвортой хөдөө аж ахуйг хөгжүүлэх төслүүдийг санхүүжүүлэх, байгаль орчинд ээлтэй, эрчим хүчний хэмнэлтийг дэмжих хөнгөлөлттэй зээлийн бүтээгдэхүүнийг иргэдэд хүртээмжтэй хүргэх чиглэлд хамтран ажиллаж байгаа билээ.

Энэ хүрээнд Голомт банк эрчим хүчний хэмнэлттэй шийдлийг дэмжсэн “Ногоон өрх” хэрэглээний зээлийн бүтээгдэхүүнийг шинээр нэвтрүүллээ.

Энэхүү зээлийг эрчим хүчний болон усны хэмнэлттэй дулаалга, гэрэлтүүлэг, цахилгаан бараа, халаалтын цахилгаан зуух гээд гэр хорооллын агаар, хөрсний бохирдлыг бууруулах бүх төрлийн хэрэгслээс өрхийн хэрэглээндээ худалдан авахаар төлөвлөж буй хувь хүн, иргэнд олгох юм.




ГОЛОМТ БАНК
Сайн сайхныг санхүүжилнэ


ADB
ASIAN DEVELOPMENT BANK


НОГООН ӨРХ

ХЭРЭГЛЭЭНИЙ ЗЭЭЛ

Зээлийн хэмжээ:	50,000,000₮ хүртэл
Хугацаа:	60 сар хүртэл
Хүү /сарын/:	1.0% - 1.3%
Урьдчилгаа:	0 ₮

БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛӨЛ

ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

ОНЦЛОХ ҮЙЛ АВДАЛ

САНХҮҮ ҮР ДҮН

ХОЛВОО БАРИХ



Ногоон зээлийн багцаар дамжуулан
нийгэмд үзүүлж буй нөлөөлөл

4,477

ажлын байр

ЭМЭГТЭЙ 48%

205

тэрбум төгрөгийн
нэмүү өртөг



ЖИЖИГ ДУНД БИЗНЕСИЙН ОРЧНЫ НӨЛӨӨЛӨЛ



She Leads 2026

470
гаруй бизнес эрхлэгч
эмэгтэйчүүд



**Sukhbaatar Business
Conference**

120
бизнес эрхлэгчид



Women Owned Business Tour

30
WO тохирлын тэмдэгтэй бизнес
эрхлэгч эмэгтэйчүүд



**Supporting Her Dreams Event
Featuring Eurochamber**

80
Харилцагч
байгууллагууд



Экспортыг Дэмжих Хөтөлбөр

30
экспортлогч бизнес эрхлэгч
эмэгтэйчүүд



**Компани Үүсгэн Байгуулах
Workshop**

30
бизнес эрхлэгчид



**Франчайз Бэлэн Байдал
workshop**

40
бизнес эрхлэгчид



**МЕНТОРШИП 2026 – Хаврын
Элсэлт**

40
бизнес эрхлэгчид

НИЙГМИЙН НӨЛӨӨЛӨЛ



Төгсөгчдийг Дадлагажуулагч Хөтөлбөр

Ажиллах хүчний тасралтгүй нөөц бүрдүүлэх, банкны ирээдүйн мэргэжилтнүүдийг бэлтгэх зорилгын хүрээнд их, дээд сургуулиудтай хамтын ажиллагаагаа идэвхтэй өргөжүүлж, өнөөдрийн байдлаар Монгол улсын нэр хүнд бүхий томоохон 8 их, дээд сургуультай хамтран ажиллаж байна. (СЭЗИС, МУИС, ШУТИС, МИС, ХИС, ИЗОУИС, ХААИС, ОТИС) Тус хөтөлбөрийн хүрээнд 100 гаруй оюутныг ажлын байранд суурилсан дадлагын хөтөлбөрт амжилттай хамруулж, 270 гаруй шинэ төгсөгчийг ажлын байраар хангалаа.



G-Volunteer Хөтөлбөр


Нийгмийн хариуцлагын хүрээнд зорилтот бүлгийг дэмжих, сайн үйлсэд хувь нэмэр оруулах зорилгоор жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг "Хайраа хуваалцъя" аянд нийт 1500 гаруй ажилтан, 4,500 хүн цагийг зориулсан бол "G-Volunteer" хөтөлбөрийг 2025 оноос эхлүүлж нийт 440 гаруй оюутан сурагчдыг 6 удаагийн сайн дурын үйл ажиллагаанд амжилттай хамрууллаа.




II УЛИРЛЫН САНХҮҮ ҮР ДҮН

САНХҮҮГИЙН ҮР ДҮН


ЗАХ ЗЭЭЛД ЭЗЛЭХ ХУВЬ /5-Р САР/




Нийт хөрөнгө ▲4.4%
/тэрбум төгрөг/
ЖДӨХ: 29% (2023-2025)



Нийт зээл ▲7.2%
/тэрбум төгрөг/
ЖДӨХ: 31%




Татан төвлөрүүлсэн хөрөнгө ▲3.7%
/тэрбум төгрөг/
ЖДӨХ: 29%




ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ЭДИЙН ЗАСГИЙН НӨХӨЛ БАЙДАЛ
ОНИЦЛОХ ҮЙЛ АВДАЛ
САНХҮҮҮР ДҮН
ХОЛВОО БАРИХ


Нийт зээлийн бүтээгдэхүүн ▲7.2%
/тэрбум төгрөг/




Бизнесийн зээл ▲5.0%
/тэрбум төгрөг/




Чанаргүй зээлийн харьцаа
/хувь/



Иргэдийн зээл ▲10%
/тэрбум төгрөг/



Чанаргүй зээлийн сангийн хүрэлцээ
/хувь/






ХАРИЛЦАГЧДААС ТАТСАН ЭХ ҮҮСВЭР


Нийт харилцах, хадгаламж ▲ 7.8%
/тэрбум төгрөг/

Хадгаламж ▼ 0.9%
/тэрбум төгрөг/


Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар
/хувь/



Харилцах ▲ 19.9%
/тэрбум төгрөг/




Зээл, эх үүсвэрийн харьцаа
/хувь/




САНХҮҮГИЙН ҮР ДҮН


Цэвэр ашиг
/тэрбум төгрөг/




Өөрийн хөрөнгө ▲11%
/тэрбум төгрөг/
ЖДӨХ: 28%




Өөрийн хөрөнгийн хүрэлцээ
/хувь/




Холбоотой этгээдэд олгосон зээл



Холбоотой этгээдэд олгосон зээл



Гадаад валютын эрсдэлийн харьцаа
/хувь/



БАЯРЛАЛАА



<https://www.golomtbank.com/investor-relations>




investornews@golomtbank.com



1800-1646

Цахим залилангаас урьдчилан сэргийлье!

Цахим залилан улам итгэл төрүүлэхүйц болж байна.
Нууц мэдээллээ хэзээ ч холбоосоор орж бүү оруул.
Албан ёсны сувгийг л ашигла.



Санамж: Сэжигтэй холбоос дээр дарсан, мэдээллээ оруулсан, эсвэл файл татсан бол цаг алдалгүй банк руугаа мэдэгдэж, шаардлагатай тохиолдолд “102” болон “51-265666” дугаарт хандана уу.